

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИНТАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арванхоёрдугаар сарын 10-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 07 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 1 цаг 02 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Галсангийн Ганболдыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод дарга санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Зам тээврийн яамны Стратегийн бодлого төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Рэнцэндоржийн Ононг Зам, тээврийн яамны Стратегийн бодлого,</p>

		<p>төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Чойжамцын Оюунтуяаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөрт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Говьсүмбэр, Булган аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 11 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Булган, Говьсүмбэр аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг</p>

хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Булган, Говьсүмбэр аймагт 2015 оны 11 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 71 иргэн /Булган аймагт 51, Говьсүмбэр аймагт 20/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэн /Булган аймагт 12, Говьсүмбэр аймагт 2/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 18 /Булган аймагт 15, Говьсүмбэр аймагт 3/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэн /Булган аймагт 7, Говьсүмбэр аймагт 1/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.

3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 26 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ

		<p>авахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлд, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Б.Батдэлгэр/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/2430 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Гочоогийн Нарангэрэлийг 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 13 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Г.Нарангэрэлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга 2015 оны

	<p>үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>арванхоёрдугаар сарын 02-ны өдрийн 3/4925 тоот албан бичгээр Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, хуралдаанаас гарсан саналуудыг томилох эрх бүхий субъектэд уламжилж, 2016 оны 01 дүгээр сарын 04-нд бүртгэн, сонгон шалгаруулалтын бүртгэлийг, 2016 оны 01 дүгээр сарын 05-нд зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
7	<p>Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ш.Солонгын 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/2321 тоот албан бичгээр Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлуулах захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
8	<p>Бусад асуудал /Зарим хүнд "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдэг олгох тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж,

		<p>тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга Жамсрангийн Бямбадоржийг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах</p> <p>2. “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Хүний эрхийн үндэсний комиссын дарга Жамсрангийн Бямбадоржод баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА